



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/91

Ховд

Зарим үйлчилгээний байгууллагуудад цагийн
хязгаарлалт тогтоож, зарим үйлчилгээг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “в”, 29.1.6-ын “а”, “ж”, “л” заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 08 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үйлчилгээний байгууллагуудын ресторан, кафе, зоогийн газруудыг 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 3 дугаар сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд архи, согтууруулах ундаагаар үйлчлэхийг хориглож, 10.00-17.00 цагийн хооронд хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байхаар цагийн хуваарийг тогтоосугай.

2.Захирамжийг олон нийтэд мэдээлж, сурталчлан, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/91 Ch
02 00403